



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 дугаар сарын 23

№ 01/82 ДЧА-дд/8/11/СДА -ТЗ

Мандалговь хот

Г

Т


Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гурвансайхан сумын 2017 оны жилийн эцсийн орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа нь шинж чанарын хувьд материаллаг, үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангаагүй тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 28.1 /Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нолохийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжлэх зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/ гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

Дундговь аймгийн Гурвансайхан сумын санхүүгийн албаны дарга У.Алимаад сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 20-ны дотор гаргаж, аймгийн Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхтуяад даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

<p>АУДИТОР</p> <p>ОГСӨН!</p> <p>Ж.УГТАХБАЯР</p>  	<p>ДАРГА</p> <p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>Б.ЭНХТУЯА</p>
---	--

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.